ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 10 сарын 29 өдөр Дугаар А/167 Баян-Өндөр сум

Ээлжит бус хуралдаан
зарлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3, 46.6 дахь хэсгүүд, 48 дугаар зүйлийн 48.3 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын 2022 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 07 дугаар тогтоолоор батлагдсан "Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлийн ажиллах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 02/11 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан "Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны дэг"-ийн 5.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 9 дэх удаагийн сонгуулийн Ээлжит бус VIII хуралдааныг 2025 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр цахим хэлбэрээр зарлан хуралдуулж, дараах асуудлуудыг хэлэлцүүлэхээр бэлтгэл хангасугай. Үүнд:

1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулах тухай;

2.Цэргийн дүйцүүлэх алба хаах иргэдийн тоог батлах тухай;

3.Аймгийн хэмжээнд ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах 2025 оны ажлын төлөвлөгөөний биелэлт, 2026 оны ажлын төлөвлөгөө батлах тухай.

2.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ээлжит бус VIII хуралдааны бэлтгэл хангах арга хэмжээний төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

3.Хуралдааны бэлтгэл хангах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллахыг Зөвлөлийн гишүүдэд даалгасугай.

ДАРГА Д.МӨНХБАТ

Албан хэрэгцээнд

6125070364

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
даргын 2025 оны 10 дугаар сарын 29-ний
өдрийн А/163 дугаар захирамжийн хавсралт

АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ЭЭЛЖИТ БУС VIII ХУРАЛДААНЫ БЭЛТГЭЛ ХАНГАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ээлжит бус VIII хуралдааныг зарласан тухай аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид, Засаг дарга, холбогдох байгууллага, албан тушаалтан, иргэдийг мэдээллээр хангах;

X/29-нд багтаан — Ажлын алба

2.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлийн гишүүдийг сонгож батлах тухай асуудлын танилцуулга, гарах шийдвэрийн төслийг бэлтгэж Хурлын Зөвлөлийн болон Хурлын хуралдаанд оруулж хэлэлцүүлэх;

X/30, XI/04, XI/07-ны дотор — Аймгийн ИТХ-ын дарга Д.Мөнхбат

3.Цэргийн дүйцүүлэх алба хаах иргэдийн тоог батлах тухай асуудлын илтгэл, холбогдох тооцоо, судалгаа, лавлагаа, гарах шийдвэрийн төслийг хавсаргаж Ажлын албанд ирүүлэх, Хурлын Зөвлөлийн болон Хурлын хуралдаанд оруулж хэлэлцүүлэх;

X/30, XI/04, XI/07-ны дотор — Аймгийн Засаг дарга Б.Зоригтбаяр

4.Аймгийн хэмжээнд ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах 2025 оны ажлын төлөвлөгөөний биелэлт, 2026 оны ажлын төлөвлөгөө батлах тухай асуудлын илтгэл, холбогдох тооцоо, судалгаа, лавлагаа, гарах шийдвэрийн төслийг хавсаргаж Ажлын албанд ирүүлэх, Хурлын Зөвлөлийн болон Хурлын хуралдаанд оруулж хэлэлцүүлэх;

X/30, XI/04, XI/07-ны дотор — Аймгийн Засаг дарга Б.Зоригтбаяр

5.Хуралдаанаар хэлэлцэх асуудалтай холбогдуулан холбогдох Хороод ажиллаж санал дүгнэлт гаргах;

XI/05-ны дотор — Холбогдох Хороод

6.Техник зохион байгуулалтын бэлтгэл ажлыг хангах;

XI/07-ны дотор — Ажлын албаны дарга Ш.Ганболд

АЖЛЫН АЛБА